



**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2014 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот


**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Ухаалаг засаг” төслийг Улсын Их Хурлаар батлуулах бэлтгэл ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Ажлын хэсэг удирдамжийн дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж, тайланг газрын удирдлагад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /З.Энхболд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЖАДАМБАА

110250

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2014 оны 01 сарын 21 өдрийн 21 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:

З.Энхболд Тус газрын дэд дарга

Нарийн бичгийн дарга:

Ч.Нургул Харилцаа холбоо, дэвшилтэт технологийн албаны ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Р.Отгонтулга Монгол улсын Ерөнхий сайдын Мэдээллийн технологийн зөвлөх

Ч.Даваажамц Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)

Н.Туяа Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (зөвшилцсөнөөр)

Л.Мягмарсүрэн Үндэсний статистикийн хорооны Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга (зөвшилцсөнөөр)

Ц.Түвшинтөр Мэдээллийн технологийн үндэсний паркийн захирал

Г. Энхцог Үндэсний дата төвийн захирал

Ш.Хандмаа Тус газрын Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын хууль эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Э.Бямбасүрэн Тус газрын Шинэчлэлийн бодлого төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, инновацийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

С.Алтанцэцэг Үндэсний статистикийн хорооны "МОНСТАТ" төслийн зохицуулагч (зөвшилцсөнөөр)

Ё.Оюун-Эрдэнэ Тус газрын Шинэчлэлийн бодлого төлөвлөлтийн газрын Сансар, радио холбооны хэлтсийн мэргэжилтэн



Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны  
Газрын даргын 2014 оны 01 сарын 21 өдрийн  
21 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН ЕРӨНХИЙ УДИРДАМЖ

Зорилго: Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх “Ухаалаг засаг” төслийг  
Улсын Их Хурлын чуулганаар батлуулах бэлтгэл ажлыг зохион байгуулах

Хугацаа: 2014 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс 2014 оны 3 дугаар сарын 31-  
ний өдөр хүртэл

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. “Ухаалаг засаг” төслийг санхүүжүүлэгч Дэлхийн банкны Монгол улс дахь суурин төлөөлөгчийн газрын удирдлага, тус төслийн Дэлхийн банкны ажлын хэсэгтэй хамтран ажиллах
2. Дэлхийн банкнаас гаргасан төслийн үнэлгээний баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах талаар Дэлхийн банктэй зөвшилцөж, тохиролцох
3. Эдийн засгийн хөгжлийн яаманд төслийн танилцуулга хийх ажлыг зохион байгуулах
4. Төслийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэх, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах
5. Улсын Их Хурлын чуулганд төслийн танилцуулга хийх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах

Тайлан: Ажлын хэсгийн үйл ажиллагааны тайланг гаргаж 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр газрын удирдлагад танилцуулна.